

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 05 ДУГААР ХУРАЛ**

2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 15 цаг 30 минутад эхэлж, мөн өдрийн 15 цаг 15 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 01 цаг 05 минутад хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцад 2019 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн тухай	1. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад “аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөрүүдийн биелэлтэд 2 жилд 1 удаа хяналт-шинжилгээ үнэлгээ хийнэ” гэж заасны дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцад 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Б.Гомбосүрэн, тус хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Гантөмөр нарт үүрэг болгов.
2	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд 2020 оны 02 дугаар сарын 15-ны байдлаар дахин хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн тухай	1.Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад “аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн болон дэд хөтөлбөрүүдийн биелэлтэд 2 жилд 1 удаа хяналт- шинжилгээ үнэлгээ хийнэ” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд 2020 оны 02 дугаар сарын 15-ны байдлаар дахин хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Б.Гомбосүрэн, тус хэлтсийн мэргэжилтэн Ц.Оюунчимэг нарт үүрэг болгов.
3	Засаг даргын нөөц хөрөнгийн хүлээгдэж буй гүйцэтгэлийн тухай	1.Засаг даргын нөөц хөрөнгийн хүлээгдэж буй 8,877,113 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс гаргахыг

		аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдалд, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболд нарт тус тус үүрэг болгов.
--	--	--

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР